



МОНГОЛ УЛСЫН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 402

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1."Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ журмыг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн "Журам батлах тухай" 54 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Л.ЦЭДЭВСҮРЭН

24001385

Төрийн албаны зөвлөлийн  
2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн  
402 дугаар тогтоолын хавсралт

## ТӨРИЙН АЛБАН ТУШААЛД ТУРШИЛТЫН ХУГАЦАА ХЭРЭГЛЭХ БОЛЗОЛ, ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн албан тушаалд анх томилогдсон иргэнд туршилтын хугацаа хэрэглэхэд энэ журмыг мөрдөнө.

1.2. Төрийн албан тушаалд туршилтын хугацааг хэрэглэхэд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан зарчмыг баримтална.

1.3. Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 13, 14 дүгээр зүйлд тус тус заасан албан тушаалуудад туршилтын хугацаа хэрэглэх зохицуулалтыг Хөдөлмөрийн тухай хууль, салбарын хууль, тогтоомжид заасныг баримтлан хэрэгжүүлнэ.

1.4. Төрийн албан тушаалд туршилтын хугацаагаар томилогдсон албан хаагчийн эрх, үүрэг, хариуцлага нь төрийн албан хаагчтай адил байна.

### Хоёр. Туршилтын хугацаа хэрэглэх болзол

2.1. Төрийн жинхэнэ албан тушаалд анх томилогдох дараах болзол хангасан иргэнд туршилтын хугацааг хэрэглэнэ:

2.1.1. Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгч томилогдсон байх;

2.1.2. Төрийн албаны тухай хуульд заасан төрийн үйлчилгээний албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтгасны дагуу сонгон шалгаруулалтад орж, томилогдсон байх;

2.1.3. Төрийн албаны тухай хуульд заасан төрийн улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцуулсны дагуу сонгон шалгаруулалтад орж, томилогдсон байх;

2.1.4. Төрийн жинхэнэ албанаас хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэн дахин хууль тогтоомжийн хүрээнд ерөнхий болон тусгай шалгалт өгч томилогдсон байх.

2.2. Төрийн үйлчилгээний албаны албан тушаалд тавигдах шаардлагыг хангах эсэхийг нь шалгах зорилгоор туршилтаар ажиллуулж болно.

2.3. Төрийн жинхэнэ албанд анх орсон иргэнийг тухайн ажлын байранд тавигдах шаардлага, хариуцах чиг үүргийг мэргэжлийн түвшинд, чанартай, үр дүнтэй

хэрэгжүүлэх чадварыг шалгах зорилгоор туршилтын хугацааг 6-12 сар хүртэл байхаар тогтоох шийдвэрийг томилох эрх бүхий этгээд гаргана.

2.4. Төрийн үйлчилгээний албан тушаалын чиг үүрэг, гүйцэтгэлийн хэмжүүр, хариуцлагатай уялдуулан туршилтаар ажиллуулах хугацаа гурван сараас илүүгүй байна. Томилох эрх бүхий этгээд, албан хаагч, ажилтан нар харилцан тохиролцсоноор туршилтын хугацааг нэг удаа гурван сараас илүүгүй хугацаагаар сунгаж болно.

2.5. Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацаагаар томилогдон ажиллаж байгаа албан хаагчийг тухайн хугацаанд бусад төрийн байгууллага, нэгж, албан тушаалд шилжүүлэх буюу сэлгэн ажиллуулахыг хориглоно.

#### **Гурав. Туршилтын хугацааны ажил, гүйцэтгэл, үнэлгээ**

3.1. Туршилтын хугацаанд ажиллаж байгаа албан хаагч нь үйл ажиллагаандаа тухайн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллана.

3.2. Томилох эрх бүхий этгээд нь туршилтаар ажиллах албан хаагчийн туршилтын хугацаанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан, гэрээ байгуулна.

3.3. Туршилтаар ажиллаж буй албан хаагч нь ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнг чиг үүргийн дагуу хариуцсан нэгжийн удирдлага, томилох эрх бүхий этгээдийн өмнө хариуцна.

3.4. Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг Засгийн газраас баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу үнэлнэ.

3.5. Төрийн үйлчилгээний албан тушаалд туршилтаар ажиллаж байгаа албан хаагч, ажилтныг "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам (ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн олгох)-ын дагуу үнэлнэ.

3.6. Энэ журмын 3.4, 3.5-д заасан үнэлгээний дүнг тухайн байгууллагын удирдлагын багийн хурлаар хэлэлцэн албан хаагчийг албан тушаалд жинхлэх эсэх шийдвэр гаргана.

3.7. Албан хаагч, ажилтныг тухайн албан тушаалд жинхлэх эсэхийг ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан шийдвэрлэнэ:

3.7.1. Ажлын гүйцэтгэл, үр дүнгээр улирал, хагас жилээр "Маш сайн" үнэлэгдсэн;

3.7.2. Ажлын гүйцэтгэл, үр дүнгээр улирал, хагас жилээр "Хэвийн" үнэлэгдсэн.

3.8. Туршилтын хугацаагаар ажиллаж буй албан хаагчийг холбогдох хууль, тогтоомжид заасан үндэслэл, ажлын гүйцэтгэл, үр дүнгээр улирал, хагас жилд "Хангалтгүй" үнэлэгдсэн бол туршилтын хугацааг дуусгавар болгож, чөлөөлнө.

## **Дөрөв.Бусад**

4.1.Энэ журмын 3.6-д заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалд жинхлэн томилогдсон албан хаагчийг холбогдох журмын дагуу тангараг өргүүлнэ.

4.2.Байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагч нь туршилтын хугацаагаар томилогдсон албан хаагчийн мэдээллийг төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд бүртгэх бөгөөд Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба хяналт тавина.

4.3.Туршилтын хугацаагаар томилогдон ажиллаж байгаад энэ журмын 3.8-д заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн албан хаагчийг хууль, журмын дагуу дахин төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох тохиолдолд туршилтын хугацаа хэрэглэж болно.

--- оОо ---